БАТЛАВ
ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Н.ХОНГОРЗУЛ

САЙНШАНД СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ХОЙД ТАЛЫН АВТО ЗАМЫГ ОФИЦЕРИЙН ТӨВ ЗАМТАЙ ХОЛБОХ 0.577 КМ АВТО ЗАМ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 01-р сарын 28-ний өдөр *Сайншанд сум*

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын 1 дүгээр багт 2 дугаар сургуулийн арын замыг оффицерийн төв замтай холбох 0.577 км асфальтбетон хучилттай авто зам *шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.*

1. Ажил гүйцэтгэх хугацааны график төлөвлөгөө (хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүч, машин механизмын тоо)-г тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи ажлын аргачлалыг гаргаж ирүүлнэ.
2. Зам, замын байгууламжийн ажлыг зам, замын байгууламжийн норм ба дүрэм /БНбд/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.
3. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.
4. Ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.
5. Зураг төсвийн үнэ 10 000 000 төгрөгийг тооцож ирүүлэх.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Авто замын барилга угсралтын ажлыг батлагдсан зураг, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Зам, замын байгууламжийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
3. Ажлыг гүйцэтгэхдээ талбайн хэмжилт, гадаслагаа зэргийг зурагт заагдсан кординат трассын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
4. Авто замын барилга угсралтын ажлыг авто зам барих ажлын технологийн дарааллын дагуу гүйцэтгэнэ.
5. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартын дагуу гүйцэтгэнэ.
6. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.

Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.

7. Зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг, самбар байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.

8. Барилга угсралтын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгаа, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.

9. Барилга угсралтын ажлыг зурагт зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.

10. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

11. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

12. Гүйцэтгэгч нь барилгын ажлыг ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналь хэрэгжүүлэх эрх бүхий зам, замын байгууламжийн зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

13. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч өөрийн эрхийн дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

14. Автозамын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т заасны дагуу Шинээр барьж байгуулсан авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа нь гүйцэтгэгч болон техник, технологийн хяналт тавьсан хуулийн этгээдэд тус бүр гурван жил байна.

Тендерийн материалд тавигдах шаардлага:

1. Төсөв тооцоонд “Авто замын барилгын ажлын жишиг норм” БНбД 81-25-07, “Төмөр бетон гүүр хоолойн барилгын төсвийн жишиг норм” БНбД 81-28-07 суурь нормууд болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн 256 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНбД 81-013-2019-ыг ашиглан хийж гүйцэтгэнэ.

2. Ажилчдын тарифт цалинг “Зам, тээврийн хөгжлийн сайд”-ын 2019 оны 256 дугаар тушаалаар батлагдсаны дагуу ажилчдын үндсэн цалин, нэмэгдэл цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операточдын цалин, нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн нийлбэрээс 15.1%-иар бодож төсөвт тусгах, Авто тээврийн зардлыг “Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ”-ийн дагуу тус тус төсөвт тусгах.

3. Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дүгээр зүйлд заасны дагуу ажил олгогч (компани)-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер, техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11.7%-иар Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу "Үйлдвэрлэлийн осол мэргэжлаас шалтгаалсан өвчний даатгал"-ын шимтгэлийн хувь хэмжээг 2.8%-иар нийт 14.5%-иар тооцно.

4. ЗТАЖ-ын сайдын 2007 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 187 тоот тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63,5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71,8%-иар тооцно.

5. Захиалагчийн хяналтын зардлыг төсвийн 2%, магадалшгүй ажлын зардлыг 2%, нэмэгдсэн өртгийн албан татварыг "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуулийн 11-р зүйлийн 11.1-р заалтын дагуу барилга угсралтын ажлын зардлын 10%-иар тооцож төсөвт тусгах.

6. ХАБЭА-н үйл ажиллагааны зардлыг шууд зардлын дүнгээс 2.5%-иар тооцно, энэ зардал нь "Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм"-ийн дагуу замын барилгын ажлын туршид хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал юм.

7. Норм, нормативын санг 0.4%-иар тооцно.

8. Үнийн тарифыг ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

9. Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын мэргэшсэн инженертэй байх.

Ажлын тоо хэмжээ:

№	АЖЛЫН НЭР	Х/Н	ТОО
	Үйлдвэрлэлийн зохион байгуулалт		
1	Замын чиг сэргээх	1 км	0.577
2	Ургамалын үе хуулах 20 см	1 м3	1298.44
3	Ул хөрсийг индүүдэж нягтруулах	1 м3	973.7
4	Тохиромжгүй материалыг ухаж ачих	1 м3	1287.19
5	Зөөврөөр далан байгуулах	1 м3	211.83
6	Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах 30 см	1 м3	2292.45
7	Буталсан чулуун суурь байгуулах 20 см	1 м3	886.77
8	Халуун асфальтбетон хольцоор өнгө хучилт байгуулах Н-3см	1 м3	133.02
9	Халуун асфальтбетон хольцоор суурь хучилт байгуулах Н-4см	1 м3	177.35
10	Хайрган хөвөөг автогрейдерээр байгуулах	1 м3	579.09
11	Замын хашлага тавих	1 у/м	1197
12	Явган хүний замын хашлага тавих	1 у/м	1187

13	Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийх 10см	1 м3	178.74
14	Явган хүний замын хучилтийг өнгөт хавтангаар хийх	1 м2	1787.41
15	Замын тэмдэг суурилуулах	1ш	33
16	Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар хийх	1 м	550
17	Халуун асфальтбетон хольцоор хурд сааруулагч хийх /6 байрлалд/	1 м3	5.6
18	ИШС-тэй хэсэгт П хэлбэрийн лоток байрлуулах	1 ш	148
19	ИШС-тэй хэсэгт тагийг замын түвшинд тааруулах	1 ш	4
20	Өөрийн шуудуу автогрейдерээр байгуулах	1 м3	216
21	Гадаргуун ус зайлуулах лоток байгуулах /1000*300*160мм/	1 у/м	30
22	Гадаргуун ус зайлуулах лоток байгуулах тагтай УЗС-1 /1990*520*465мм/	1 у/м	30
23	Хөрсний шинжилгээ	1 удаа /1000 м3/	2
24	Элсний шинжилгээ	1 удаа /1000 м3/	2
25	Битумын шинжилгээ	1 тн	2
26	Хучилтаас дээж өрөмдөж авах	1 удаа /700м/	2
27	Обьектийг ашиглалтанд оруулах	1 км	0,577

АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ЗТХХЭХ-НЫ МЭРГЭЖИЛТЭН: /Д.ЧИНХАНД/

ХЯНАСАН:

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА /А.АМГАЛАНЗАЯА/